

2024 оны 2 сар 15 өдөр

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12, Инновэйшн Инвестмент компанийн дүрмийн 16 дугаар зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Инновэйшн Инвестмент ХК-ийн 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 21.63 /хорин нэгэн төгрөг жаран гурван мөнгө/ төгрөгөөр тогтоож, Компанийн 2023 оны цэвэр ашгийн 70.2 /дал аравны хоёр/ хувь буюу 4,000,000,000.00 /дөрвөн тэрбум/ төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуй нэгжийн орлогын албан татвар суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар ногдол ашгийг 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн дотор олгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ДАВАА